



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өлгий сумын Хүүхдийн 15 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: **БӨА-2025/172/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:

www.audit.mn

Өлгий хот

2025 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын,
дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл
Утас: 70422954 Цахим хаяг: aigul@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек
Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Лайт энд Дилайт Аудит ХХК-ийн захирал: М.Нурболат
Утас: 70007275 Цахим хаяг: lightanddelightaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
4.5.1 Завсрын аудитын талаар	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	20
5.1 Зөвлөмж	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

**ӨЛГИЙ СУМЫН ХҮҮХДИЙН
15 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Х.СЕРКЕШХАН ТАНАА**

2025.02.24 № 162
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өлгий сумын хүүхдийн 15 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Өлгий сумын хүүхдийн 15 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Өлгий сумын хүүхдийн 15 дугаар цэцэрлэг нь 2024 онд 842.9 сая төгрөгийн батлагдсан төсвөөр ажиллаж, гүйцэтгэлээр 711.6 сая төгрөг зарцуулж, 84.4 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Өлгий сумын хүүхдийн 15 дугаар цэцэрлэгийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөнд тусгагдсан 1 зорилго, 4 зорилтын хүрээнд нийт 88 арга хэмжээ 90.4 хувийн биелэлттэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.АЙГҮЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	134,925,027.71	157,625,956.71
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	115,089,331.38	131,242,465.71
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	115,089,331.38	131,242,465.71
3121	Төгрөг	115,089,331.38	131,242,465.71
31211	Төрийн сангийн харилцах	115,089,331.38	131,242,465.71
33	АВЛАГА	2,848,329.33	329,440.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	329,440.00
335	Бусад авлага	2,848,329.33	-
3351	Байгууллагаас авах авлага	2,848,329.33	-
35	БАРАА МАТЕРИАЛ	16,987,367.00	26,054,051.00
354	Хангамжийн материал	16,987,367.00	26,054,051.00
35410	Бичиг хэргийн материал	-	603,000.00
35420	Аж ахуйн материал	8,971,916.00	18,788,916.00
35440	Түлш, шатах тослох материал	4,783,400.00	35,000.00
35450	Барилгын засварын материал	-	370,700.00
35460	Хүнсний материал	1,356,251.00	3,449,735.00
35470	Бусад хангамжийн материал	1,875,800.00	2,806,700.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	411,927,037.82	447,309,509.43
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	411,927,037.82	447,309,509.43
392	Биет хөрөнгө	400,439,798.82	436,178,080.15
39201	Барилга, байгууламж, орон сууц	441,986,198.00	475,439,476.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(57,106,191.28)	(65,803,459.38)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	27,001,600.00	43,084,800.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(17,278,385.18)	(21,138,705.27)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	26,284,051.00	26,284,051.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(22,728,113.84)	(23,861,995.64)
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,212,790.00	2,212,790.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(430,769.88)	(537,496.56)
39217	Ном	498,620.00	498,620.00
393	Биет бус хөрөнгө	11,487,239.00	11,131,429.28
39301	Програм хангамж	2,083,239.00	2,083,239.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(660,000.00)	(1,015,809.72)
39303	Бусад биет бус хөрөнгө	10,064,000.00	10,064,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	546,852,065.53	604,935,466.14
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	420,242.17	3,047,599.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	420,242.17	3,047,599.00
413	Өглөг	420,242.17	3,047,599.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	420,242.17	2,729,299.00
4136	Бусад өглөг	-	318,300.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	318,300.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	546,431,823.36	601,887,867.14
51	Засгийн газрын хувь оролцоо	546,431,823.36	601,887,867.14
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	12,166,790.00	12,166,790.00
51101	Өмч:- төрийн	12,166,790.00	12,166,790.00
512	Хуримтлагдсан үр дүн	534,265,033.36	589,721,077.14
51210	Өмнөх үеийн үр дүн	534,265,033.36	534,265,033.36
51220	Тайлант үеийн үр дүн	-	55,456,043.78
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	546,852,065.53	604,935,466.14

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	535,298,839.00	780,675,178.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,779,239.00	52,896,278.00
120	Нийтлэг татварын бус орлого	5,779,239.00	50,896,278.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,779,239.00	50,896,278.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	5,779,239.00	43,757,278.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		7,139,000.00
122	Тусламжийн орлого	-	2,000,000.00
122001	Хандив тусламж /дотоод/	-	2,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	529,519,600.00	727,778,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	508,775,700.00	681,923,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	508,775,700.00	681,923,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	20,743,900.00	45,855,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	20,743,900.00	45,855,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	442,579,663.42	725,219,134.22
21	УРСГАЛ ЗАРДАЛ	442,579,663.42	725,219,134.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	442,579,663.42	725,219,134.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	308,897,671.06	525,794,901.00
210101	Үндсэн цалин	219,056,843.67	430,268,371.00
210102	Нэмэгдэл	76,246,727.39	88,087,080.00
210104	Урамшуулал	13,594,100.00	7,439,450.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,672,442.17	66,036,392.83
210201	Тэтгэврийн даатгал	34,032,742.17	44,695,040.22
210202	Тэтгэмжийн даатгал	3,910,100.00	5,248,405.03
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,127,800.00	2,992,276.83
210204	Ажилгүйдлийн даатгал	781,800.00	2,620,131.24
210205	Эрүүл мэндийн даатгал	7,820,000.00	10,480,539.51
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,166,900.00	48,554,300.00
210301	Гэрэл, цахилгаан	3,227,900.00	8,177,900.00
210302	Түлш, халаалт	10,139,000.00	21,676,400.00
210303	Цэвэр, бохир ус	800,000.00	1,500,000.00
210304	Байрны түрээс	-	17,200,000.00
2105	Нормативт зардал	40,978,850.00	58,888,134.00
210502	Хоол, хүнс	40,978,850.00	58,888,134.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	447,600.00
210604	Урсгал засвар	500,000.00	447,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	358,800.00	1,959,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	358,800.00	1,959,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28,005,000.19	23,538,606.39
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,269,900.00	2,004,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,532,850.00	7,380,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	19,202,250.19	14,154,006.39
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	92,719,175.58	55,456,043.78
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	92,719,175.58	55,456,043.78

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	529,519,600.00	727,778,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	529,519,600.00	727,778,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	681,923,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	681,923,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	508,775,700.00	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	508,775,700.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	20,743,900.00	45,855,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	20,743,900.00	45,855,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	426,045,968.39	707,846,565.67
21	УРСГАЛ ЗАРДАЛ	426,045,968.39	707,846,565.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	426,045,968.39	707,846,565.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	309,530,873.39	514,794,747.67
210101	Үндсэн цалин	219,690,046.00	388,937,253.67
210102	Нэмэгдэл	76,246,727.39	118,779,193.00
210104	Урамшуулал	13,594,100.00	7,078,301.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,252,200.00	72,208,600.00
210201	Тэтгэврийн даатгал	33,612,500.00	49,101,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,910,100.00	5,776,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,127,800.00	2,888,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	781,800.00	2,888,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,820,000.00	11,553,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,243,900.00	45,355,900.00
210301	Гэрэл, цахилгаан	3,227,900.00	9,727,900.00
210302	Түлш, халаалт	16,216,000.00	16,128,000.00
210303	Цэвэр, бохир ус	800,000.00	1,500,000.00
210304	Байрны түрээс	-	18,000,000.00
2105	Нормативт зардал	37,247,445.00	60,981,618.00
210502	Хоол, хүнс	37,247,445.00	60,981,618.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	500,000.00
210604	Урсгал засвар	500,000.00	500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	358,800.00	1,959,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	358,800.00	1,959,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,912,750.00	12,046,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,034,950.00	6,596,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,877,800.00	5,450,200.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	103,473,631.61	19,932,334.33
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	3,779,200.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	3,779,200.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	3,779,200.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	3,779,200.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(3,779,200.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	103,473,631.61	16,153,134.33
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		115,089,331.38
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	115,089,331.38	131,242,465.71

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	/Төгрөгөөр/
			Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	12,166,790.00	441,545,857.78	453,712,647.78
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	12,166,790.00	441,545,857.78	453,712,647.78
Тайлант үеийн үр дүн	-	92,719,175.58	92,719,175.58
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	12,166,790.00	534,265,033.36	546,431,823.36
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	12,166,790.00	534,265,033.36	546,431,823.36
Тайлант үеийн үр дүн	-	55,456,043.78	55,456,043.78
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	12,166,790.00	589,721,077.14	601,887,867.14

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	/Төгрөгөөр/	
				Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	842,868,200.00	711,625,765.67	131,242,434.33	84.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	842,868,200.00	711,625,765.67	131,242,434.33	84.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	842,868,200.00	711,625,765.67	131,242,434.33	84.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	627,855,600.00	514,794,747.67	113,060,852.33	82.0
210101	Үндсэн цалин	461,286,000.00	381,804,756.67	79,481,243.33	82.8
210102	Нэмэгдэл	155,768,500.00	125,911,690.00	29,856,810.00	80.8
210104	Урамшуулал	10,801,100.00	7,078,301.00	3,722,799.00	65.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	74,225,700.00	72,208,600.00	2,017,100.00	97.3
210201	Тэтгэврийн даатгал	50,474,700.00	49,101,900.00	1,372,800.00	97.3
210202	Тэтгэмжийн даатгал	5,937,000.00	5,776,700.00	160,300.00	97.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,968,900.00	2,888,300.00	80,600.00	97.3
210204	Ажилгүйдлийн даатгал	2,968,900.00	2,888,300.00	80,600.00	97.3
210205	Эрүүл мэндийн даатгал	11,876,200.00	11,553,400.00	322,800.00	97.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,355,900.00	45,355,900.00	-	100.0
210301	Гэрэл, цахилгаан	9,727,900.00	9,727,900.00	-	100.0
210302	Түлш, халаалт	16,128,000.00	16,128,000.00	-	100.0
210303	Цэвэр, бохир ус	1,500,000.00	1,500,000.00	-	100.0
210304	Байрны түрээс	18,000,000.00	18,000,000.00	-	100.0
2105	Нормативт зардал	74,092,000.00	60,981,618.00	13,110,382.00	82.3
210502	Хоол, хүнс	74,092,000.00	60,981,618.00	13,110,382.00	82.3

Өлгий сумын хүүхдийн 15 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	500,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	500,000.00	500,000.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,959,200.00	1,959,200.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,959,200.00	1,959,200.00	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,879,800.00	15,825,700.00	3,054,100.00	83.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,429,600.00	10,375,500.00	3,054,100.00	77.3
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,450,200.00	5,450,200.00	-	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	842,868,200.00	727,778,900.00	115,089,300.00	86.3
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	681,923,000.00	681,923,000.00	-	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	681,923,000.00	681,923,000.00	-	100.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	45,855,900.00	45,855,900.00	-	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	45,855,900.00	45,855,900.00	-	100.0
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	115,089,300.00	-	115,089,300.00	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		115,089,331.38		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		131,242,465.71		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	37	37	-	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	16	16	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	20	20	-	100.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Өлгий сумын хүүхдийн 15 дугаар цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсрол олгох чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм. Эрхэм зорилго нь “Тохилог орчин чанартай сургалт явуулахад оршино.”

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус цэцэрлэг үйл ажиллагаандаа Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай, Нийгмийн даатгалын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай /Шинэчилсэн найруулга/, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулиудыг мөрдлөг болгон хэрэгжүүлдэг байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай /Шинэчилсэн найруулга/
- Засгийн газрын 2024 оны 32 дугаар тогтоол “Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам” батлах тухай
- Засгийн газрын 2024 оны 39 дүгээр тогтоол “Хувьсах зардлын хэмжээ, итгэлцүүр, журам” батлах тухай
- Засгийн газрын 2024 оны 104 дүгээр тогтоол “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн багш, ажилтанд мөнгөн тэтгэмж олгох журам” батлах тухай
- Засгийн газрын 2024 оны 237 дугаар тогтоол “Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэн тогтоох” тухай
- Засгийн газрын 2024 оны 84 дүгээр тогтоол “Тогтоолд хавсралт нэмэх, тогтоолын хавсралт өөрчлөн батлах” тухай
- Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоол “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай”

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Баян-Өлгий аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас санхүүгийн баримтад шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өлгий сумын хүүхдийн 15 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Өлгий сумын хүүхдийн 15 дугаар цэцэрлэгийн эрхлэгчийн 2022 оны 01 дугаар сарын 21-ны өдрийн А/08 тоот тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байна. Энэхүү нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинээр гарсан хууль эрхийн актуудтай нийцүүлэн шинэчлэх шаардлагатай байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Өлгий сумын хүүхдийн 15 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2023 оны 229 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 58,083.5 мянган төгрөгөөр буюу 10.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	115,089.3	131,242.5	16,153.2
Авлага	2,848.3	329.4	(2,518.9)
Бараа материал	16,987.4	26,054.1	9,066.7
Үндсэн хөрөнгө	411,927.0	447,309.5	35,382.5
Нийт хөрөнгө	546,852.0	604,935.5	58,083.5
Өр төлбөр	420.2	3,047.6	2,627.4
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	546,431.8	601,887.9	55,456.1
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	546,852.0	604,935.5	58,083.5

Өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан нь мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, авлага, өглөг, эздийн өмчийн данс байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 16,153.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд 727,778.9 мянган төгрөгийн санхүүжилт авч 711,625.7 мянган төгрөгийг үйл ажиллагаанд зарцуулсантай холбоотой байна.

Авлагын дансны үлдэгдэл 329.4 мянган төгрөг болж 2,518.9 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны авлагыг барагдуулсантай холбоотой байна.

Бараа материал дансны үлдэгдэл 26,054.1 мянган төгрөг болж 9,066.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд 7,139.0 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авч, урсгал санхүүжилтээс 89,477.0 мянган төгрөгийн худалдан авалт хийж, 87,549.3 мянган төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаанд зарцуулсантай холбоотой.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 447,309.5 мянган төгрөг болж, 35,382.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 45,757.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авч, 3,779.2 мянган төгрөгөөр хөрөнгө худалдан авч, 14,154.0 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсонтой холбоотой.

Өр төлбөр дансны үлдэгдэл 2,627.4 мянган төгрөгөөр өссөн нь 2,779.3 мянган төгрөгийн ХАОАТ-ын өглөг, 318.3 мянган төгрөгийн байгууллагад өгөх өр төлбөрийг барагдуулаагүйтэй холбоотой.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 601,887.9 мянган төгрөг болж 55,456.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлан оны үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 518,125.9 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 27,365.4 мянга, нийт зарлагыг 545,491.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 21,355.9 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлыг 500,0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 70.6 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 5,589.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 60,330.3 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 7,541.4 мянган төгрөг, төгрөгөөр бууруулж, 431,165.2 мянган төгрөгөөр баталсан. Энэ нь төсвийг бодитой, үндэслэлтэй төлөвлөөгүйтэй холбоотой байна.

Тодотголоор 411,846.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж нийт төсвийг 842,868.2 мянган төгрөгөөр баталсан байна. Үүнд цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал зардлыг 308,958.9 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 34,363.7 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 24,000.0 мянган төгрөг, нормативт зардлыг 36,966.7 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардлыг 1,213.4 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 6,200.3 мянган төгрөгөөр тус тус нэмж тодотгосон байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 681,923.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, 45,855.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 115,089.3 төгрөгийг оны эхний үлдэгдлээс бүрдүүлэхээр төсөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 681,923.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 45,855.9 мянган төгрөг, нийт 727,778.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд оны эхний үлдэгдлээс 115,089.3 мянган төгрөг, тайлант хугацааны санхүүжилтээс 596,536.4 мянган төгрөг, нийт 711,625.8 мянган төгрөг зарцуулсан байна.

Нийт төсвийн гүйцэтгэл 711,625.8 мянган төгрөг буюу 84.4 хувьтай байгаа нь боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх төсвийг 115,626.8 мянган төгрөг, цэцэрлэгийн хүүхдийн хоолны төсвийг 13,110.4 мянган төгрөг, боловсролын байгууллагын багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх төсвийг 1,383.4 мянган төгрөгөөр хэмнэсэн буюу тодруулбал, цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 113,060.8 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 2,017.1 мянган төгрөг, нормативт зардлыг 13,110.4 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 3,054.1 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2.Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71801 - сургуулийн өмнөх боловсрол	842,868.2	711,625.8	131,242.4	84.4
1.1	80111 - төрийн өмчийн байгууллагын тогтмол зардал	45,855.9	45,855.9	-	100.0
1.2	80233 - хүүхэд хамгаалал	930.9	930.9	-	100.0
1.3	81605 - эрүүл мэндийг дэмжих	1,118.8	1,040.0	78.8	93.0
1.4	81807 - цэцэрлэгийн хүүхдийн хоол	74,092.0	60,981.6	13,110.4	82.3
1.5	81816 - зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр	1,999.4	1,999.4	-	100.0
1.6	81823 - боловсролын байгууллагын багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх	1,383.4	-	1,383.4	0.0
1.7	81834 - боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	716,314.4	600,687.5	115,626.9	83.9
1.8	81835 - сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	1,173.4	130.4	1,043.0	11.1

Хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөсөн төсвийн гүйцэтгэл 84.4 хувийн биелэлттэй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Санхүүгийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлийн судалгааны дүн дараах байдалтай байна. Үүнд:

Өлгий сумын 15 дугаар цэцэрлэг нь Ахмадын тухай хууль, Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолоор баталсан “Ахмадын сан ажиллуулах журам”-ыг хэрэгжүүлээгүй буюу ахмадын сан байгуулж ажиллаагүй байна.

Тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө баталж ажиллаагүй байна.

Бараа үйлчилгээний бусад зардлын дансаар 10.4 сая төгрөгийг зарцуулсан байна.

Байгууллагын 2024 оны орон тооны судалгааг гаргуулан авч хянаж үзэхэд Боловсрол, шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын 2024 оны А/85, А/34 дүгээр хамтарсан тушаалаар баталсан хүүхдийн цэцэрлэгийн багш, ажилтны орон тооны хязгаарын жишиг нормативыг баримтлан ажилласан байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

2024 оны төсвийн жилд худалдан авалтын төлөвлөгөө гараагүй, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлээгүй байна.

Тайлант онд хүнсний материал 60,981.6 мянган төгрөг, хангамжийн материал 930.9 мянган төгрөг, түлш, шатах тослох материал 16,926.5 мянган төгрөг, аж ахуйн материал 2,678,0 мянган төгрөг, бичиг хэргийн материал 7,183.0 мянган төгрөг, барилгын засварын материал 777.0 мянган төгрөг, төгрөгөөр тус тус худалдаж авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Өлгий сумын 15 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотойгоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Лайт энд Дилайт Аудит” ХХК-ийн аудитор Л.Мөнхцэцэг гүйцэтгэж, аудитын менежер Ц.Төмөрсүх, компанийн захирал М.Нурболат нар анхан шатны чанарын хяналтыг, Баян-Өлгий аймаг дахь төрийн аудитын газрын аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Өлгий сумын хүүхдийн 15 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймгийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайланг, суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 428,579.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 6,638.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллаа явуулсан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 31 шалгуур үзүүлэлтээр горим сорил хэрэгжүүлсэн. Алдаа, зөрчил илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 14 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш нийт 22 удаагийн 704,549.3 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээ мэдээлэхээс 18 удаагийн 462,389.3 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээг хугацаа хоцроосон байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.1 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2 заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь байршуулаагүй мэдээллийг нөхөж байршуулан зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн төсвийн зарцуулалт нь Төсвийн тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар эхний хагас жилийн санхүүгийн тайланд аудит хийж, байгууллага, түүний орчин, дотоод хяналт, дотоод аудитын талаар ойлголт олж аван эрсдэл тодорхойлж, аудитын ерөнхий стратеги боловсруулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 9,600.0 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн нь 100 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	9,600.0	1	9,600.0	100.0
Нийт дүн	1	9,600.0	1	9,600.0	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Энэхүү аудитаар цэцэрлэгийн өмч хөрөнгийн хадгалалт, ашиглалт, төсвийн зарцуулалтыг бүрэн шалгах боломжгүй тул эрсдэлтэй гэж сонгосон данс, ажил гүйлгээнүүдэд горим сорил хэрэгжүүлсэн.

Гүйцэтгэлийн шалгалтаар өмч хөрөнгийн хадгалалт, ашиглалт, төсвийн зарцуулалтыг дэлгэрэнгүй шалгах шаардлагатай гэж үзэв.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой алдаа¹ илрээгүй болно.

Аудитаар нийт 1,471.0 мянган төгрөгийн 2 зөрчил² илэрснээс, балансын урамшуулалтай холбоотой 1,471.0 мянган төгрөгийн албан шаардлага, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөвлөмж өгсөн.

5.1 Албан шаардлага

Аудитаар санхүүгийн ажилтантай холбоотой зөрчилд 1 албан шаардлага хүргүүлэв.

1.БСШУЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 2/2772 дугаар бүхий албан бичгээр хүргүүлсэн чиглэлийн дагуу цэцэрлэгийн эрхлэгчийн тушаалаар нягтлан бодогчид 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний 1,471.0 мянган төгрөгийн балансын урамшуулал олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5-д “Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 16.5.5-т “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Засгийн газрын 2019 оны “Журам батлах тухай” 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.2-т “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн ажилчдад олгох мөнгөн урамшууллыг холбогдох хууль, журам зөрчиж тогтоосон хэмжээнээс хэтрүүлэн олгохгүй байх, цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүллээ.

5.2 Зөвлөмж

Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлсэн нь: Тайлант хугацаанд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлээгүй, шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (ТБОНӨБАҮХАТ)-ийн 44 дүгээр зүйлийн 44.1 “Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална”, 10 дугаар зүйлийн 10.3 “Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно”, 10.5 “Захиалагч өрсөлдөөнийг дэмжих зорилгоор бараа, ажил, үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/;

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

байдлаар багцалж болно", 45 дугаар зүйлийн 45.3. "Энэ хуулийн 45.2-т заасан жагсаалтад хамаарахгүй улсын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр санхүүжүүлэх өөрийн хэрэгцээнд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний хувьд төсвийн шууд захирагч захиалагч байна", Засгийн газрын 2025 оны "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар"-ыг тус тус зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу худалдан авах ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлж ажиллах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Үүнээс										Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Тайлант хугацаанд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлээгүй, шууд худалдан авалт хийсэн байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
БСШУЯамны ТНБ-ийн даргын 2024.06.24-ний өдрийн 2/2772 дугаар бүхий албан бичгээр хүргүүлсэн чиглэлийн дагуу байгууллагын эрхлэгчийн тушаалаар нягтлан бодогч, эд хариуцагч нарыг 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний урамшуулал тус тус олгосон байна.	1	1,471.0	-	-	1	1,471.0	-	-	-	-	-	-
ДҮН	2	1,471.0	-	-	1	1,471.0	1	-	-	-	-	-

/мянган төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил						Үүнээс			
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Шилэн дансны цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш нийт 22 удаагийн 704,549.3 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээ мэдээлэхээс 18 удаагийн 462,389.3 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээг хугацаа хоцроосон байна.	1	-	-	-	-	-	-	1	-	
ДҮН	1	-	-	-	-	-	-	1	-	

/мянган төгрөгөөр/